



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2023/7/НА-СТА-ОНӨААН

Цахим хуудас: www.audit.mn	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Батчимэг Утас: 91113253 Цахим хаяг: batchimegn@audit.gov.mn
Баянхонгор 2023 оны 03 дугаар сарын 20	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	8
Дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгад гарсан өөрчлөлтүүд	9
4. Аудитын тайлан	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал.....	10
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.4.2 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.4.3 Завсрын аудитын талаар.....	11
4.4.4 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
5. Аудитын илрүүлэлт.....	12
5.1 Төлбөрийн акт	12
5.2 Албан шаардлага.....	13
5.3 Зөвлөмж	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2023.03.20 № 2/123

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр “Талын нөмөр” ХХК хийсэн 198,916.8 мянган төгрөгийн өртөг бүхий шинэ хогийн цэгийн байгууламж, *ОС* ХХК-иас нийлүүлсэн 178,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий өөрөө явагч дугуйт экскаватор нийлүүлэгдсэнийг бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 23 арга хэмжээг төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 80.7 хувьтай дүгнэсэн байна.

• 005020521

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2022 оны 2022 оны санхүүгийн тайланд толилууаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
31	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>58,156,176.33</u>	<u>58,840,216.77</u>
312	МӨНГӨН ХӨРӨНГӨ	22,547,794.76	602,922.10
3121	Банкинд байгаа бэлэн мөнгө	22,547,794.76	602,922.10
31213	Төгрөг	22,547,794.76	602,922.10
33	Арилжааны банк дахь харилцах	22,547,794.76	602,922.10
33401	АВЛАГА	2,534,590.16	2,534,590.16
33402	Дансны авлага /ТӨҮГ/	1,080,000.00	1,080,000.00
35	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	1,454,590.16	1,454,590.16
354	БАРАА МАТЕРИАЛ	33,073,791.41	55,702,704.51
35410	Хангамжийн материал	31,693,791.41	54,322,704.51
35420	Бичиг хэргийн материал	659,000.00	708,120.00
35430	Аж ахуйн материал	24,442,961.41	47,892,154.51
35600	Сэлбэг хэрэгсэл	6,591,830.00	5,722,430.00
2	Мал амьтад	1,380,000.00	1,380,000.00
39	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>185,438,112.74</u>	<u>577,200,347.73</u>
392	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	185,438,112.74	577,200,347.73
39201	Биет хөрөнгө	185,438,112.74	538,980,347.73
39202	Барилга, байгууламж, орон сууц	17,220,049.00	17,220,049.00
39203	Хуримтлагдсан элэгдэл	6,888,019.60	8,610,024.50
39204	Авто-тээврийн хэрэгсэл	559,157,000.00	737,157,000.00
39205	Хуримтлагдсан элэгдэл	387,004,250.00	415,294,916.67
39206	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,539,000.00	10,386,000.00
39207	Хуримтлагдсан элэгдэл	2,706,500.00	4,493,611.11
39208	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,771,800.00	11,147,800.00
39214	Хуримтлагдсан элэгдэл	6,650,966.67	7,448,800.00
39215	Бусад үндсэн хөрөнгө	1,200,000.00	200,116,851.00
393	Хуримтлагдсан элэгдэл	1,200,000.00	1,200,000.00
39301	Биет бус хөрөнгө	-	38,220,000.00
39302	Программ хангамж	869,000.00	869,000.00
39303	Хуримтлагдсан элэгдэл	869,000.00	869,000.00
3	Бусад биет бус хөрөнгө		38,220,000.00
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>243,594,289.07</u>	<u>636,040,564.50</u>
41	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>278,000.00</u>	<u>39,008,447.10</u>
413	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	278,000.00	39,008,447.10
4136	Өглөг	278,000.00	39,008,447.10
41362	Бусад өглөг	278,000.00	39,008,447.10
41364	Татварын өглөг /ТӨҮГ/		5,080,699.24
41366	НДШ - ийн өглөг /ТӨҮГ/		13,832,137.20
5	Дансны өглөг /ТӨҮГ/	278,000.00	20,095,610.66
51	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>243,316,289.07</u>	<u>597,032,117.40</u>
511	Засгийн газрын хувь оролцоо	243,316,289.07	597,032,117.40

51101	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	612,440,438.00	612,440,438.00
512	Өмч: - төрийн	612,440,438.00	612,440,438.00
51210	Хуримтлагдсан үр дүн	(369,124,148.93)	(15,308,320.60)
51220	Өмнөх үеийн үр дүн	(369,124,148.93)	(369,124,148.93)
6	Тайлант үеийн үр дүн		353,815,828.33
31	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>243,594,289.07</u>	<u>636,040,564.50</u>

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	740,059,901.00	1,199,850,991.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	740,059,901.00	1,199,850,991.00
120	Нийтлэг татварын бус орлого	740,059,901.00	1,199,850,991.00
120009	Бусад орлого		422,136,851.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	740,059,901.00	777,714,140.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	690,744,941.74	846,135,162.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	690,744,941.74	846,135,162.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,744,941.74	846,135,162.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	690,744,941.74	846,135,162.67
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	214,808,810.42	200,131,536.66
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	158,438,714.90	98,872,051.00
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	296,697,006.42	341,466,250.90
210813	Бусад зардал /ТӨҮГ/	20,800,410.00	205,665,324.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>49,314,959.26</u>	<u>353,715,828.33</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>49,314,959.26</u>	<u>353,715,828.33</u>

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C02	НББ-ийн бодлогын өөрчлөлт	383,846,398.00		(154,421,804.67)		229,424,593.33
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	383,846,398.00	-	(154,421,804.67)	-	229,424,593.33
C07	Тайлант үеийн үр дүн	228,594,040.00		(214,702,344.26)		13,891,695.74
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.00	-	(369,124,148.93)	-	243,316,289.07
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	612,440,438.00	-	(369,124,148.93)	-	243,316,289.07
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	612,440,438.00	-	369,124,148.93)	-	243,316,289.07
D08	Тайлант үеийн үр дүн	-		353,715,828.33		353,715,828.33
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	612,440,438.00	-	(15,308,320.60)	-	597,032,117.40

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>740,059,901.00</u>	<u>777,714,140.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	740,059,901.00	777,714,140.00
120	Нийтлэг татварын бус орлого	740,059,901.00	777,714,140.00
120009	Бусад орлого	73,817,601.00	59,764,140.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	666,242,300.00	717,950,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>717,538,870.47</u>	<u>799,659,012.66</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	717,538,870.47	799,659,012.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	717,538,870.47	799,659,012.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	286,050,195.00	336,064,896.00
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	286,050,195.00	336,064,896.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,038,023.00	76,721,448.00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн/ТӨҮГ/	114,038,023.00	76,721,448.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,676,460.00	9,943,707.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	6,676,460.00	9,943,707.00
2104	Хангамж, бараа материалын зардал	221,243,926.00	250,938,126.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	199,227,386.00	224,974,476.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	22,016,540.00	25,963,650.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,530,266.47	125,990,835.66
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	41,961,716.47	20,087,499.66
210817	Даатгалын төлбөрт төлсөн /ТӨҮГ/	1,619,450.00	-
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	45,949,100.00	105,903,336.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>22,521,030.53</u>	<u>(21,944,872.66)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	22,521,030.53	(21,944,872.66)
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,547,794.76	(22,547,794.76)

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Д/Д	Зардал	2022 он			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,764.23	22,547,794.76	(22,521,030.53)	84.2
2	УРСГАЛ ЗАРДАЛ	1,400,000,000.00	799,659,012.70	600,340,987.30	57.1
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,381,337,400.00	781,023,856.70	600,313,543.30	56.5

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,284,800.00	394,640,336.70	12,644,463.30	96.9
210101	Үндсэн цалин	407,284,800.00	394,640,336.70	12,644,463.30	96.9
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	50,910,600.00	50,910,600.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	50,910,600.00	50,910,600.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,701,300.00	7,130,989.00	570,311.00	92.6
210301	Гэрэл, цахилгаан	1,757,300.00	1,708,467.00	48,833.00	97.2
210302	Түлш, халаалт	2,600,000.00	2,078,522.00	521,478.00	79.9
210303	Цэвэр, бохир ус	264,000.00	264,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	3,080,000.00	3,080,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	147,964,100.00	185,898,404.00	(37,934,304.00)	125.6
210401	Бичиг хэрэг	3,140,400.00	2,717,450.00	422,950.00	86.5
210402	Тээвэр, шатахуун	140,092,900.00	179,213,926.00	(39,121,026.00)	127.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,372,800.00	914,228.00	458,572.00	66.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,358,000.00	3,052,800.00	305,200.00	90.9
2105	Нормативт зардал	8,880,000.00	8,357,950.00	522,050.00	94.1
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,880,000.00	8,357,950.00	522,050.00	94.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,838,000.00	65,972,130.00	(13,134,130.00)	124.9
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,530,000.00	5,530,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	14,908,000.00	14,552,500.00	355,500.00	97.6
210604	Урсгал засвар	32,400,000.00	45,889,630.00	(13,489,630.00)	141.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,906,100.00	8,356,447.00	1,549,653.00	84.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	850,000.00	850,000.00	-	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,328,000.00	2,328,000.00	-	10.0
	ТУЗ-н зардал	2,400,000.00	1,189,500.00	1,210,500.00	49.6
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,078,100.00	3,738,947.00	339,153.00	91.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	695,852,500.00	59,757,000.00	636,095,500.00	8.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	51,361,000.00	(51,361,000.00)	
	Гэрээт зардал	695,852,500.00	8,396,000.00	687,456,500.00	1.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,662,600.00	18,635,156.00	27,444.00	99.9
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,662,600.00	18,635,156.00	27,444.00	99.9
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	18,662,600.00	18,635,156.00	27,444.00	99.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	150,000,000.00	169,600,000.00	(19,600,000.00)	113.1

132001	Орон нутгийн төсвөөс	150,000,000.00	150,000,000.00	-	100.0
	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	19,600,000.00	(19,600,000.00)	
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	550,000,000.00	608,114,140.00	(58,114,140.00)	110.6
1200041	Санхүүгийн дэмжлэг	550,000,000.00	567,950,000.00	(17,950,000.00)	103.3
	Орон сууцны орлого	-	40,164,140.00	(40,164,140.00)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын зорилго нь “Аюулгүй ажиллагааг эрхэмлэн ард түмний итгэл найдварыг алдахгүй, түргэн шуурхай үйлчилгээг ард түмэнд хүргэж ажиллах”-д оршино.

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ нь 2022 онд менежментийн ерөнхий төлөвлөгөөг удирдлага болгон нийт нутаг дэвсгэрийнхээ хог хаягдлыг нэгдсэн цэгт төвлөрүүлэх, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн хог хаягдлыг стандартын дагуу тээвэрлэх, цэвэр орчныг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна.

Мөн гэр хорооллын 8,666 айл өрх орон сууцны 1,660 айл өрх, төрийн болон хувийн хэвшил аж ахуйн нэгж 332 байгууллага иргэдийн хог хаягдлын тээвэрлэж байна.

Тус байгууллага нь захиргаа аж ахуйн, тээвэр засвар үйлчилгээ, орон сууц гэсэн 3 нэгжтэй, 48 орон тоотой үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт 1,400,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Тайлант жил хөрөнгө зарцуулахад нэгдүгээр гарын үсгийг Ц.Баясгалан, хоёрдугаар гарын үсгийг ерөнхий нягтлан бодогч Л.Баттөмөр нар зурж, нярваар Г.Нацагюмсүрэн ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Цэвэр хот” ОНӨААТҮГ нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулаагүй, Сангийн яамны шаардлага хангасан аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан гаргадаг Leader-3, Payroll санхүүгийн программ хангамж ашигладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй шинээр батлагдсан Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэн байна.

Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 2022 оны 1, 2, 3 дугаар улирлыг хамруулан шалгалт хийсэн харин санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Цэвэр хот” ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тодруулгад гарсан өөрчлөлтүүд

Цэвэр хот ОНӨААТҮГ-ын санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	58,156.2	58,840.2	684.0
Мөнгөн хөрөнгө	22,247.7	602.9	(21,644.8)
Авлага	2,534.6	2,534.6	0.0
Бараа материал	33,073.8	55,702.7	22,628.9
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	185,438.1	577,200.3	391,762.2
Үндсэн хөрөнгө	185,438.1	577,200.3	391,762.2
Хуримтлагдсан элэгдэл	(38,859.2)	(32,597.6)	(6,261.6)
Нийт хөрөнгө	243,594.3	636,040.5	392,446.2
Өр төлбөр	278.0	39,008.4	38,730.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	243,316.3	597,132.1	353,815.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	243,594.3	636,040.5	392,446.2

Эх сурвалж: 2021 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 602.9 мянган төгрөг болж 21,644.8 мянган төгрөгөөр буурсан ба үлдэгдэл Хаан банкны 5249036765 тоот харилцах дансанд үлдэгдлээр байгаатай холбоотой байна.

Татварын хэлтсээс авах 2018 онд үүссэн НӨАТ-ын 2,534.6 мянган төгрөгийн авлагыг татварын тооцоонд суутган тооцоо хийх албан бичгийг татварын хэлтэст явуулсан боловч тайлант онд шийдвэрлэх боломгүй гэсэн хариу ирсэн тул өр төлбөр барагдуулаагүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 55,702.7 мянган төгрөг болж 22,628.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 23,449.2 мянга, сэлбэг хэрэгсэл 771.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой бөгөөд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 281,881.9 мянган төгрөгийн бараа материалыг орлого авч 257,820.9 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 577,200.3 мянган төгрөг болж 391,762.2 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 9,223.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдаж авсан, ОНХС-ийн эх үүсвэрээр “Талын нөмөр” ХХК хийсэн 198,916.8 мянган төгрөгийн өртөг бүхий шинэ хогийн цэгийн байгууламж, *ОС* ХХК-иас нийлүүлсэн 178,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий өөрөө явагч дугуйт экскаватор нийлүүлэгдсэнийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 5/86 дугаар албан бичгийн дагуу орлого авч бүртгэсэнтэй холбоотой байна.

Цаашид Аймгийн ИТХ-ын тогтоолоор хөрөнгөд орлого авах шийдвэр гараагүй байхад хөрөнгө орлого авахгүй байх зөвлөмж өгөв.

Өр төлбөр дансны үлдэгдэл 39,008.4 мянган төгрөг болж 38,730.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь НДШ-ийн 13,832.1 мянга, ХХОАТ-ын 5,080.7 мянга, шатахууны 20,095.6 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 636,040.0 мянган төгрөг болж 392,446.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн 392,446.2 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

3.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт Хог хаягдлын тухай хуулийн дагуу санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Байгууллагын техник, эдийн засгийн гол үзүүлэлт нь Баянхонгор аймгийн хог хаягдлыг төвлөрсөн журмаар ачиж тээвэрлэн нэгдсэн хогийн цэгт хүргэх, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулж ашиглахтай холбоотой иргэд, аж ахуйн нэгж байгууллагын нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэн хог хаягдлыг ангилан ялгах цуглуулахтай холбоотой харилцааг зохицуулж, байгаль орчинд ээлтэй цэвэр орчныг бүрдүүлэх явдал юм.

Баянхонгор сумын ИТХ-ын 2021 оны хуралдаанаар тус байгууллагын 2022 оны хог хаягдлын хураамжийн орлогын төлөвлөгөөг 568,000.0 мянга, орон нутгийн орлогоос 150,000.0 мянга, нийт 718,000.0 мянган төгрөгөөр баталсан, Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-иас 658,668.8 мянган төгрөгийн орлого төвлөрснөөс 90,668.8 мянган төгрөгийн орлогыг тодотгол хийгээгүйгээс олгоогүй, 2023 онд олгохоор тооцсон байна.

Тайлант онд тус байгууллага нь үйл ажиллагаанаас 15,308.3 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасан бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Цэвэр хот ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг захирал Ц.Баясгалан танд танилцуулж байна

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төрийн өмч, хөрөнгийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дүгээр сарын 15-ны өдөр ирүүлсэн.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 149 дүгээр тогтоолоор ТУЗ-ийг 9 гишүүний бүрэлдэхүүнтэй баталсан бөгөөд тайлант онд 2 удаа хурал зохион байгуулсан байна..

“Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 07 тоот албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 690,744.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,361.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,252.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2022 онд 137 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 135 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 гүйлгээний 717,950.0 мянга, зарлагын 11 гүйлгээний 158,100.8 мянган төгрөгийн гүйлгээ, 15,433.8 мянган төгрөгийн 78 шийдвэрийг үнэн зөв мэдээлсэн, харин зарлагын 61,962.3 мянган төгрөгийг 6 гүйлгээг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн, мэдээллийг хугацаанд нь цахим хуудаст үнэн зөв дүнгээр байршуулах, цаашид шилэн дансны цахим мэдээлэлд тавих төсвийн шууд захирагчийн хяналтыг сайжруулах.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Аудитаар нийт 253,576.9 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 2,630.0 мянган төгрөгийн 1 алдаанд төлбөрийн акт, 1 зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 250,946.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 4 зөвлөмж өгсөн.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,630.0	1	2,630.0	100
Албан шаардлага	1	-	0	-	0
Зөвлөмж	4	250,946.9	4	250,946.9	100
Нийт дүн	6	253,576.9	5	253,576.9	67

Өмнөх аудитаар актын төлбөрийг бүрэн барагдуулсан, зөвлөмжийг хэрэгжүүлсэн талаар тус байгууллагын 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 97 тоот албан бичгээр ирүүлснийг биелэлтийг тооцож FAS системд оруулсан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант хугацаанд байгууллагын захирал суудлын автомашиныг ашиглаж 4,011.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын тэргүүн дэд, дэд, орлогч дарга болон дэд сайд, яамны төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн захирал, төсвийн байгууллагын дарга хот дотор албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байгаа ба энэ нь байгууллагын даргын дотор үйлчилгээнд хэрэглэсэн шатахууны замын хуудсыг харахад хог ачилтын хяналт хийсэн гэсэн байх тул тайлан, анхан шатны баримтыг дэлгэрүүлж хянах нь зүйтэй.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 55,492.9 мянган төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс, 3,727.7 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоож, 41,423.1 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 10,342.1 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 2 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.1.1. Тайлан хугацаанд 24 иргэнээс 28,680.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа ХХОАТ-ын 10 хувийн 2,688.1 мянган төгрөгийг суутгалгүй шилжүүлсэн байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.19 дэх “суутган төлөгч” гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг”, 28 дугаар зүйлийн 28.7 дахь “Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана”, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын ерөнхий хууль зөрчиж суутган тооцоогүй 2,688.1 мянган төгрөгийг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.2. Албан хаагчдын тамирын хувцасны үнэнд байгууллагын төсвөөс 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр 500.0 мянган төгрөгийг зарцуулж буцааж тооцоо хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журам зөрчин зориулалт бусаар зарцуулсан 500.0 мянган төгрөгийг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.1.3. Тайлант онд нярвын хүнсний тайлангаар 13,774.6 мянган төгрөгийн хүнсний материал орлого авсан байхад нягтлан бодогч хүнсний зардалд 14,314.2 мянган төгрөгийг шилжүүлсэн төсвөөс 539.6 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль журам зөрчин зориулалт бусаар зарцуулсан 539.6 мянган төгрөгийг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нараар төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1. Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 131/ГХ2021/00637 дугаар захирамжаар Захирлын 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн Б/11 дүгээр тушаалаар ажлаасаа чөлөөлөгдсөн үйлчлэгч С.Пагамдуламд ажилгүй байх хугацааны цалинд 1,034.4 мянга, НДШ-ийн 295.5 мянга, нийт 1,329.8 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосон бөгөөд буруутай албан тушаалтан захирал Ц.Баясгалангаар төлүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэсэн заалтыг зөрчиж буруутай албан тушаалтнаас хохирлыг төлүүлээгүй байгаа тул байгууллагын дансанд төлүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.2. Тайлант онд батлагдсан төсвөөс 39,121.0 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан нь шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор шатахууны зардлыг 20,095.6 мянга, цалин хөлстэй холбоотой татвар суутгалыг шилжүүлээгүйгээс НДШ-ийн 13,832.1 мянга, ХХОАТ-ын 5,080.7 мянга, нийт 39,008.4 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 дахь “байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өр төлбөрийг барагдуулах, цаашид төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага өгөв.

5.2.3. Тус байгууллага нь ажилтан албан хаагчдад сард 40.0 мянган төгрөгийн хоолны мөнгө олгож буцаан суутгаж хоол хийж өгдөг бөгөөд тайлант онд албан хаагчдаас 12,196.7 мянган төгрөгийн хоолны мөнгө суутгаж, хүнсний зардалд 14,314.2 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд төсвөөс 2,117.5 төгрөгийг илүү зарцуулж, тайлант оны эцэст 1,184.9 мянган төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1,184.9 мянган төгрөгийн хүнсний материалыг хүнсний тайланд орлого авах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1. Тайлант хугацаанд сэлбэгийн зардлаас 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдөр 173.0 мянган төгрөгийн бараа материалыг нярвын тайлангаар орлого авч зарлагадалгүй шууд зардлаар тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл,

өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.5 дахь “бүх орлого”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.3.2.Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 37,173.3 мянган төгрөгийн сэлбэг худалдан авсан бөгөөд автомашины хувийн хэрэгт 27,004.2 мянган төгрөгийн сэлбэгийг бичиж үлдэгдэл 10,169.1 мянган төгрөгийн сэлбэгийн бичилтийг хийгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Автомашины хувийн хэргийг сэлбэг авсан тухай бүр хөтлөх, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

	Үүнээс											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Зөрчлийн товч утга												
Тайлан хугацаанд 24 хувь хүнээс 28,680.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авахдаа ХХОАТ-ын 10 хувийн 2,688.1 мянган төгрөгийг суутгалгүй шилжүүлсэн байна.	1	2,688.1	1	2,688.1								
Албан хаагчдын тамирын хувцасны үнэнд байгууллагаас 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдөр 500.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.	1	500.0	1	500.0								
Баянхонгор аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 131/ГХ2021/00637 дугаар захирамжаар үйлчлэгч С.Пагамдуламд ажилгүй байх хугацааны цалинд 1,034.4 мянга, НДШ-ийн 295.5 мянга, нийт 1,329.8 мянган төгрөгийн цалинг төсвөөс нөхөн олгосон бөгөөд буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй байна.	1	1,329.8	1	1,329.8	1	1,329.8						
Тайлант онд шатахууны үнийн өсөлттэй холбоотойгоор шатахууны шатахууны зардлыг батлагдсан төсвөөс 39,121.0 мянган төгрөгийг хэтрүүлэн зарцуулснаас шалтгаалан шатахууны 19,995.6 мянга, НДШ-ийн	1	38,908.4	1	38,908.4	1	38,908.4						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(Мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн		
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 61,962.3 мянган төгрөгийг 6 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	0	0	0	0	0	1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	0

_____ 000 _____